

# БҮЛЭГ: ХУВЬ ХҮН БА ЭДИЙН ЗАСАГ

СЭДЭВ: ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хамрах хүрээ: 9 анги



# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Суралцахуйн зорилт:

- ❑ Хөдөлмөрийн зах зээлийг шинжлэн судалж, цалин хөлс, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх, ажил мэргэжлийн эрэлтэд судалгаа хийж энэ талаар зөв төсөөлөлтэй болно.



## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөлмөр гэж юу вэ?

- ❑ Хөдөлмөр бол ямар нэгэн үр ашигтай үр дүнд чиглэсэн, хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг хэлнэ.
- ❑ Хүн төрөлхтний түүх бол ямагт үйлдвэрлэлийн түүх байсаар ирсэн билээ. Хөдөлмөр нь эдийн засгийн нөөцүүдийн нэг буюу үйлдвэрлэлийн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

## Хөдөлмөрийн ангилал

.

Хөдөлмөр

**Биеийн хүчний хөдөлмөр:** бие  
махбодын үйл ажиллагаа  
давамгайлсан хөдөлмөрийг  
хэлнэ

**Оюуны хөдөлмөр:** оюун  
ухаан үйл ажиллагаа  
давамгайлсан хөдөлмөрийг  
хэлнэ

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

## Хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт , график

- Зах зээлийн эдийн засагт хүний хөдөлмөр нь бусад нөөцийн нэгэн адил арилжаа солилцооны нэг үндсэн хэрэгсэл болдог. Ажиллах хүчний арилжаа, солилцооны хийж буй хүрээг **хөдөлмөрийн зах зээл** гэнэ.
- Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн асуудал нь хөдөлмөрийн **эрэлт, нийлүүлэлт, цалин** юм.

## ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- ❑ Хөдөлмөрийн нийлүүлэлтийг ажиллах хүчин, иргэд бий болгоно.
- ❑ Хөдөлмөрийн эрэлтийг үйлдвэр, аж ахуй нэгжүүд бий болгоно.
- ❑ Хөдөлмөрийн үнийг түүнийг ашигласны төлөө төлж байгаа үнэ буюу **цалингаар** төлөөлүүлдэг.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлт , график

<https://youtu.be/XOdClKfsKRA>

Сурах бичгийн:43 хуудас:

- ❑ Хөдөлмөрийн эрэлтийн муруй
- ❑ Хөдөлмөрийн нийлүүлэлтийн муруй



# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Хөдөлмөрийн зах зээлд цалин өсөхөд байгууллагын зардал нэмэгдэж, ашиг буурна. Тиймээс ажил олгогчоос олон ажилтан авч ажиллуулах сонирхол буурна. Харин цалин буурахад хөдөлмөрийн эрэлт өснө.



# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ


- ❑ Хөдөлмөрийн зах зээлд цалингийн түвшин өсөхөд хөдөлмөр эрхлэх эрмэлзлэлтэй хүмүүсийн тоо буюу хөдөлмөрийн нийлүүлэлт өсдөг.
- ❑ Харин цалингийн түвшин буурахад хөдөлмөрийн нийлүүлэлт буурдаг.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- ❑ Цалин бол хөдөлмөрийн үнэ юм. Хөдөлмөрийн зах зээлд бусад зах зээлийн нэгэн адил гол зохицуулагч нь үнэ байдаг.
- ❑ Өөрөөр хэлбэл: Хөдөлмөрийн үнэ болох цалингийн түвшин өсөж буурах замаар хөдөлмөрийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлдэг.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Хөдөлмөрийн эрэлт нь нийлүүлэлтийнхээ хэмжээтэй тэнцэх үед хөдөлмөрийн зах зээл мөн тэнцвэржиж зохицсон цалин тогтоно. Энэ үед хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөрийн нөөцийн илүүдэл, хомсдлын аль аль нь үүсэхгүй.



# ХӨДӨЛМӨРИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ


- **Хөдөлмөрийн эрэлт:** Цалингаар баталгаажсан ажиллах хүчний хэрэгцээ шаардлага.
- **Хөдөлмөрийн нийлүүлэлт:** Хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд байгаа төрөл бүрийн мэргэжилтэй ажиллах хүчний тоо.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- ❑ Хөдөлмөрийн зах зээлийн тухай мэдэхийн тулд: Хөдөлмөр эрхлэх **нас, ажил эрхлэлт, ажиллах хүч** гэсэн ойлголтуудыг мэдэх нь чухал.
- ❑ Хөдөлмөрийн насны хүн ам: Монгол улсад 19-59 насны хүн амыг хэлдэг.
- ❑ Ажиллах хүч: 16аас дээш насны ажил эрхэлж байгааа болон бүртгэлтэй, хөдөлмөр эрхлээгүй хүмүүсээс бүрдэнэ.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Ажиллах хүчийн **эдийн засгийн идэвхтэй хүн ам** ГЭНЭ.




# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Мөн эдийн засгийн идэвхтэй бус хүн ам гэсэн ойлгол байдаг. Үүнд: 16 хүртлэх насны хүүхдүүд, тэтгэврийн насны хүн ам, ажил эрж хайхаа больсон хүмүүс багтдаг.

# ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Ажиллах хүч ба хөдөлмөрийн нөөцийн хоорондын хамаарлыг ажиллах хүчний оролцооны түвшин харуулдаг.





# Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

- ❑ Хөдөлмөрийн эрхлэлтийн түвшинг олохдоо: Хөдөлмөр эрхэлж буй хүний тоог, хөдөлмөрийн насны хүн амын тоонд хувааж, 100-д үржүүлж олно.



# Хөдөлмөрийн зах зээл дараах үүрэгтэй:

- **Ажиллах хүчийг бэлтгэнэ:** Нийгмийн эрэлт захиалагчдын хүсэлтийг үндэслэн шаардлагатай ажил мэргэжлийн хүнийг олох, бэлтгэх, давтан сургах замаар ажиллах хүчийг бэлтгэдэг.
- **Орлогын боломжийг бий болгоно:** Хөдөлмөрийн харилцаа нь аж төрөх баталгаагаа хангах цорын ганц боломж мөн.
- **Хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийг зохицуулна:** Эрэлт нийлүүлэлтийг зохицуулдаг байгууллагууд байдаг.

Дасгал ажил:

Сурах бичиг: 45хуудас

Бие дааж хийгээрэйг хийнэ үү.